

**БАТЛАВ**  
 БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
 ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
 ДАРГА И.БАТТӨГС  
 2024 оны 02 дугаар сарын 01-ны өдөр

**ГАДНА ФАСАД ЗАСВАРЫН АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 3 ДУГААР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр


Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар хуралдааны 80 дугаар тогтоол;
2	Барилга байгууламжийн байршил	- Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, 4а дугаар байр;
3	Зориулалт, Хүчин чадал	- Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, 4а байрны гадна фасадын ажил;
4	Хэрэгцээ шаардлага	- Барилгын дулааны эрчим хүч хэмнэх, есөн нэмэгдэх хэрэглээг багасгах, барилгын насжилтыг уртасгах;
5	Барилгын үндсэн бүтээц, материал	- Угсармал барилга;
6	Төслийн иж бүрдэл	<u>Баримт бичгийн иж бүрдэл</u> - Тайлбар бичиг; - Ажлын тоо хэмжээ; - Магадлалын нэгтгэсэн дүгнэлт (хавсралт дүгнэлтийн хамт);  <u>Зураг төсвийн иж бүрдэл</u> - Одоогийн байдал (фото зургаар баталгаажуулах); - Хэмжилтийн зураг төсөл; - Барилгын төсөв (Магадлалаар батлагдсан байх);
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	- Ажлын зураг төсөв нэг үе шаттай; - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох;
8	Зураг төслийн байгууллага	- Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага;
9	Захиалагч байгууллага	- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар;
10	Засвар хийгдэх ажлууд	- Орон сууцны гадна фасад засварыг төсөвт өртөлт багтаан хийж гүйцэтгэх;
11	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Хууль тогтоомж:</u> - Барилгын тухай хууль;  <u>Норм, нормативууд</u> - Олон нийтийн барилгын норм дүрэм (БНБД 31.03.03); - Барилга байгууламжийн зураг зохиох галын аюулгүй норм (БНБД 21.02.02); - Заслын ажил БНБД 31-10-05;

		<ul style="list-style-type: none"> <li>- Барилга засварын ажлын төсвийн суурь нормууд;</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм;</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм;</li> </ul> <p><u>Стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2000;</li> <li>- “Ажлын байрны бичиг цаг уурын эрүүл ахуйн хэмжээ” MNS 12.013-91;</li> <li>- “Ажлын байрны хүчдэлийн түвшин” MNS 12.097-91, MNS 12.098-91, MNS 12.101-091;</li> <li>- Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0301B;</li> <li>- Барилгын хог хаягдлын менежмент UCS1706A;</li> <li>- Бусад холбогдох стандартууд;</li> </ul>
12	Онцгой нөхцөл	<p><u>Засварын ажилд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дулаан техникийн шинэчлэлийн ажилд ашиглах материалыг сонгохдоо эрүүл ахуйн, технологи, дулаан техникийн шаардлага хангасан орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн байхыг тайлбарт тусгах;</li> <li>- Дулаалгын материал нь гарал үүслийн болон тохирлын гэрчилгээтэй, лабораторийн дүгнэлттэй байна. (Нягт нь 20кг/м<sup>3</sup>-аас багагүй байна) Дулаалгын зузааныг дулаан техникийн тооцоог үндэслэн сонгох;</li> <li>- Гадна ханын гадаргууг бэлтгэх, цэвэрлэх, сул материалыг ховхолж авах, тэгш бус гадаргууг засаж тэгшлэх, хөрсхүүлэлт хийж суурь тавих;</li> <li>- Хана дулаалгын материалын хооронд цан цохихоос сэргийлж ханын дулаалгын системийг ус чийгэнд тэсвэртэй цавуугаар нааж (Дулаалгын материал нааж тогтоохын өмнө дулаалгын хавтан тогтоох гадаргууг шалгуулах шаардлагатай);</li> <li>- Дулаалгын ажлыг БД 23-101-03-ын дагуу гүйцэтгэх тухай тайлбар бичигт тусгах;</li> <li>- Барилгын гадна ханыг доод давхрын шалнаас доош 1м, дээврийн парапет ханын ирмэг хүртэл дулаалах;</li> <li>- Фасадад хэрэглэх будгийг MNS 5252:2003 стандартын дагуу сайн чанарын зориулалтын гадна заслын будаг сонгох;</li> <li>- Барилгын тагны хог шороо, гадаргууг сайтар цэвэрлэж зориулалтын будгаар жигд будах;</li> <li>- Цонхны хаялга төмрийг сайн чанарын материал ашиглан шаардлагатай хэсгийг шинэчлэх, шаардлага хангах хуучин төмрийг буцааж тавих;</li> <li>- Хаалга, цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, амлагааг стандартын дагуу хийх;</li> <li>- Борооны усны хаялгыг засварлаж, шинэчлэх;</li> <li>- Гадна фасадын өнгийг ойр орчинтой зохицуулан хот байгуулалтын шаардлагад нийцүүлэх ба ашиглагчаас санал авахыг тайлбарт тусгах;</li> <li>- Төсвийг зохиоходоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах;</li> </ul>
13	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм (БНБД 21.01.02), (БНБД 21.02.02);</li> </ul>


14	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;
----	-----------------------------	---

ХЯНАСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.ДАВААСАМБУУ

БОЛОВСРУУЛСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



М.БИЛЭГЖАРГАЛ

ГАДНА ФАСАД ЗАСВАРЫН АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 3 ДУГААР ХОРОО)



№	Төсөл, арга хэмжээний нэр	Төрөл	Тоо, хэмжээ
1	Гадна фасад засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хорооны 4а байр)	Их засвар	2100м2

